



**ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**

**ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСГИЙН ТАЛААРХ
ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

**Улаанбаатар хот
2025 он**

ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСГИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Зорилго: Энэхүү нийтлэл нь үй олноор хөнөөх зэвсгийн талаарх ойлголт, олон улсын болон дотоодын эрх зүйн орчин, үй олноор хөнөөх зэвсгийг үл дэлгэрүүлэх олон улсын санаачлага, Монгол Улсын эрх зүйн орчин, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар олон нийт, салбарын судлаач нарт ойлголт өгөх, таниулах зорилго агуулав.

Нэг. Үй олноор хөнөөх зэвсгийн талаарх ойлголт

Үй олноор хөнөөх зэвсэг гэсэн ойлголт нь олон улсын аюулгүй байдал, цэргийн стратегийн салбарт өргөн хэрэглэгддэг ч, цаг хугацааны явцад өөрчлөгдөж, янз бүрийн утга агуулгыг илэрхийлж ирсэн.


Үй олноор хөнөөх зэвсэг гэсэн нэр томъёо нь анх 1937 онд Испанийн Гуэрника хотод болсон агаарын довтолгооноос хойш хэрэглэгдэж эхэлсэн. Энэ үед уг нэр томъёо нь их хэмжээний хөнөөл учруулах чадвартай аливаа зэвсгийг илэрхийлдэг байв. Дэлхийн хоёрдугаар дайны дараа үй олноор хөнөөх зэвсэг гэсэн нэр томъёонд цөмийн, химийн, биологийн зэвсэг багтах болов.

Нэгдсэн үндэсний байгууллагын Аюулгүйн зөвлөл 1948 онд “Үй олноор хөнөөх зэвсэг” гэж **цөмийн, химийн, биологийн** зэвсэг болон тэдгээртэй ижил хэмжээний хөнөөл учруулах чадвартай зэвсэг гэж тодорхойлсон байдаг бөгөөд өнөөг хүртэл энэхүү тодорхойлолтыг дэлхий нийтийн хэмжээнд аюулгүй байдал, батлан хамгаалах болон эрх зүйн салбаруудад түгээмэл ашиглагдаж байна.

1.1. Цөмийн зэвсэг гэж юу вэ?

“Цөмийн зэвсэг” гэж цөмийн хянагдашгүй эрчим хүч гаргаж дайны зориулалтаар ашиглаж болох цөмийн аливаа төрлийн тэсрэх төхөөрөмжийг хэлнэ¹ хэмээн тодорхойлжээ.

Тэрээр 1945 онд Хирошима, Нагасакид цөмийн зэвсэг ашиглаж 200000 гаруй хүн амь үрэгдсэнээс хойш цөмийн зэвсэг ашиглагдаагүй ч, 2000 гаруй удаагийн туршилт хийгдсэн бөгөөд 2024 оны байдлаар дэлхий нийтийн хэмжээнд ойролцоогоор 12100 ширхэг цөмийн зэвсэг хадгалагдаж байна² гэсэн судалгаа байдаг.



Улс орнууд үй олноор хөнөөх зэвсгүүдийн дотор хамгийн их хор хөнөөл учруулах аюултай зэвсэг болох цөмийн зэвсгийг устгах зорилгоор Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээнд 1968 онд нэгдэж эхэлсэн. Уг гэрээ 1970 онд хүчин төгөлдөр болсноор цөмийн зэвсгийг үл

¹ Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль

² <https://www.statista.com/statistics/263223/number-of-nuclear-tests-worldwide-by-country/>



дэлгэрүүлэх, хориглон хураах зорилгыг урагшлуулах, цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглахад чиглэсэн бөгөөд цөмийн зэвсэгтэй гүрнүүд энэ төрлийн зэвсгийг бусдад үл тараах, үйлдвэрлэх, цөмийн зэвсэггүй улсууд цөмийн зэвсгээс татгалзах үүрэг хүлээсэн билээ. Өнөөгийн байдлаар энэ гэрээнд дэлхийн 190 улс нэгдэн орсон бөгөөд БНАСАУ 1985 онд нэгдэн орсон боловч 2003 онд уг гэрээнээс гарсан байдаг³.

Цөмийн зэвсэгтэйд тооцогддог Энэтхэг, Израил, Пакистан улс уг гэрээнд нэгдээгүй байна. Олон улсын түвшинд цөмийн зэвсгээр хөөцөлддөг улс орнуудаас гадна террорист этгээд, бүлэглэлүүд энэ төрлийн зэвсгийг олж авах, түгээн дэлгэрүүлэх, бүтээхэд хүчин чармайлт гаргадаг болсон тул “Цөмийн зэвсгийг терроризмд ашиглахгүй байх” тухай Нью-Йоркын конвенц 2007 онд хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн бөгөөд 114 улс нэгдэн ороод байна⁴.

1.2. Химийн зэвсэг гэж юу вэ?

“Химийн зэвсэг” гэж төрөл, тоо хэмжээ нь эдгээр зорилгод нийцэж байгаа тохиолдолд энэхүү конвенцоор хориглоогүй зорилгод ашиглахаас бусад химийн хорт бодис болон тэдгээрийн прекурсор, тийм байлдааны хэрэгсэл, төхөөрөмж ашигласны үр дүнд химийн хорт бодисын хорт шинж ялгарч үхэлд хүргэх буюу бусад гэм хор учруулах тусгай зориулалт бүхий байлдааны хэрэгсэл, төхөөрөмжийг хэлнэ⁵ гэж тодорхойлсон байна.

Химийн зэвсэгт төв мэдрэлийн системийг хөнөөдөг зарим зоман ви-икс табун,

арьсаар дамжин хордуулдаг иприт люизит, амьсгал боогдуулдаг фосген дифосген, ерөнхий үйлчилгээтэй синилийн хүчил хлорциан зэрэг бодисууд хамаардаг. Дэлхийн нэгдүгээр дайны үед зуу гаруй мянган тонн химийн зэвсэг хэрэглэсний улмаас 1.300.000 орчим хүн амь үрэгдсэн гэж үздэг⁶.

Химийн зэвсгийг ашиглахыг олон улсын хэд хэдэн гэрээгээр хориглосон бөгөөд 1925 оны Женевийн Протокол болон 1993 оны Химийн Зэвсгийн Конвенц зэрэг гэрээ нь химийн зэвсгийн үйлдвэрлэл, нөөц бүрдүүлэх, хэрэглэхийг гишүүн улс, орнуудад хориглосон.



Энэ конвенц нь 1997 онд хүчин төгөлдөр болсон бөгөөд 195 улс нэгдэн ороод байгаа бол Египет, Израил, Өмнөд Судан, Хойд Солонгос гэсэн улсууд нэгдэж ороогүй байна. Конвенц хэрэгжиж эхэлснээс хойш 23 жилийн хугацаанд химийн зэвсгийн 98 орчим хувийг устгасан байна⁷. Конвенцид нэгдсэнээр химийн зэвсэг ашиглах, үйлдвэрлэхийг хориглох, химийн зэвсгийг устгах үүрэг хүлээнэ, харин нэгдэн ороогүй орны хувьд тодорхой хязгаарлалт тогтоосон цөөн тооны (конвенцийн хавсралтад жагсаалтаар орсон хорт болон угтвар бодис) бодисыг экспортлохыг зөвшөөрдөг⁸.

³ https://dashboard.disarmamenteducation.org/index.php?go=courses&do=course-detail&course_id=23

⁴ <https://disarmament.unoda.org/wmd/nuclear/>

⁵ Химийн зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх болон хэрэглэхийг хориглох, түүнийг устгах тухай конвенц

⁶ https://en.wikipedia.org/wiki/Chemical_weapons_in_World_War_I

⁷ https://en.wikipedia.org/wiki/Chemical_Weapons_Convention?utm_source=chatgpt.com

⁸ <https://disarmament.unoda.org/wmd/chemical/>

1.3. Биологийн зэвсэг гэж юу вэ?

“Биологийн зэвсэг” гэж гарал үүсэл, үйлдвэрлэсэн аргаас үл хамаарч урьдчилан сэргийлэх, хамгаалах болон энх тайвны бусад зориулалтын бус төрөл, тоо хэмжээний бичил биологийн, биологийн бусад бодис буюу токсин; эсхүл ийм бодис, токсинг дайсагнасан зорилго буюу зэвсэгт мөргөлдөөнд ашиглахад зориулсан зэвсэг, тоног төхөөрөмж, зөөгч хэрэгслийг хэлнэ⁹ гэж тодорхойлжээ.

1900-аад оноос эхлэн дэлхий нийтээрээ биологийн зэвсгийн эрчимтэй хөгжүүлж эхэлсэн бөгөөд дэлхий нэгдүгээр дайнд ашигласан гашуун сургамжаас үүдэн 1925 оны Женевийн Протоколоор биологийн зэвсэг ашиглахыг хориглосон ч хадгалах, хөгжүүлэхийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Харин 1972 оны Биологийн зэвсгийн конвенц (BWC)-оор биологийн зэвсгийг хөгжүүлэх, үйлдвэрлэх, олж авах, шилжүүлэх, хадгалах, ашиглахыг бүр мөсөн хориглосон¹⁰. Түүнээс хойш хугацаанд биологийн



зэвсгийг хориглох олон улсын санаачилга болох Австралийн бүлэг (Australia Group) 1985 онд байгуулагдсан бөгөөд 43 улс элсэж экспортын хяналтын тогтолцоог бэхжүүлэх, биологийн болон химийн зэвсэг дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдсэн. НҮБ-ын Аюулгүйн зөвлөл 2004 онд 1540 дугаар

тогтоолыг баталж, гишүүн орнуудыг химийн, биологийн, цөмийн зэвсгийг хязгаарлахад чиглэгдсэн зохицуулалтын арга хэмжээ авахыг үүрэгжүүлсэн байдаг¹¹.

Хоёр. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх олон улсын эрх зүйн зохицуулалт

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх, дэлхий нийтийн болон бүс нутгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор олон улсын хамтын нийгэмлэгээс гэрээ, хэлэлцээр, конвенцуудыг санаачлан хэрэгжүүлж байна. Өөрөөр хэлбэл гишүүн улс, орнууд дагаж мөрдөх үүрэг бүхий эрх зүйн баримт бичгүүд бөгөөд олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Үй олноор хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэх чиглэлээр дараах гэрээ, конвенцууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд:

- **Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ (NPT, 1968 он)** – Цөмийн зэвсэгтэй улс орнууд цөмийн зэвсгийг бусад улсад түгээхгүй, ашиглуулахгүй байх, цөмийн зэвсэггүй улсууд цөмийн зэвсэг үйлдвэрлэхгүй байх, цөмийн материалыг зөвхөн энхийн зорилгоор ашиглах нөхцөлийг бий болгох зорилготой.
- **Химийн зэвсгийг хориглох тухай конвенц (CWC, 1993 он)** – Химийн зэвсэг үйлдвэрлэх, хуримтлуулах, ашиглахыг бүрэн хориглох зорилготой.
- **Биологийн зэвсгийг хориглох тухай конвенц (BWC, 1972 он)** – Биологийн зэвсэг болон токсин хөгжүүлэх, үйлдвэрлэх, хадгалах, ашиглахыг хориглох зорилготой.
- **Цөмийн туршилтыг хориглох гэрээ (CTBT, 1996 он)** – Цөмийн туршилтыг бүрэн хориглож, дэлхий даяар хяналтын систем бий болгохыг зорилготой.

⁹ Биологийн зэвсгийн конвенц

¹⁰ <https://disarmament.unoda.org/biological-weapons/>

¹¹ https://dashboard.disarmamenteducation.org/index.php?go=courses&do=course-detail&course_id=23

- **Зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх тухай Гаагийн Түншлэл (НСОС, 2002 он)** – Баллистик пуужингийн технологийн хөгжүүлэлтийг хязгаарлах зорилготой.
- **НУБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1540 тогтоол (2004 он)** – Үй олноор хөнөөх зэвсгийг түгээн дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэх, түүнийг хууль бусаар үйлдвэрлэх, олж авах, тээвэрлэх, дамжуулах болон ашиглахыг хориглох, хяналт тавих хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилготой.

Гурав. Үй олноор хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэх олон улсын санаачилга

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх чиглэлээр зөвхөн олон улсын гэрээ, хэлэлцээр төдийгүй олон талт болон хоёр талт санаачилгууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр санаачилга нь тодорхой бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдолтой бараа бүтээгдэхүүн, технологийн экспортын хяналтын тогтолцоо бүрдүүлэх зорилготой байдаг. Үүнд:

- **Австралийн бүлэг (Australia Group, 1985 он)** – Энэ бүлэг нь химийн болон биологийн зэвсгийг үл дэлгэрэлүүлэх зорилготой бөгөөд 43 улс, Европын Холбоо (ЕХ) гишүүнээр элссэн¹². Тус бүлэгт багтсан улс, орнуудад химийн болон биологийн зэвсэг үйлдвэрлэхэд ашигладаг материалыг экспортлох хяналтыг сайжруулах үүрэг хүлээлгэсэн байдаг.
- **Цөмийн нийлүүлэгчдийн бүлэг (NSG, 1975 он)** – NSG нь цөмийн материал, тоног төхөөрөмж, технологийн худалдааг хянах, цөмийн зэвсэг үйлдвэрлэхэд ашиглагдаж болзошгүй технологийг хязгаарлах зорилготой бөгөөд уг бүлэгт 48 улс гишүүнээр элссэн байна¹³.
- **Вассенаарын зохицуулалт (WA, 1996 он)** – Стратегийн ач холбогдол бүхий бараа, технологийн экспортын хяналтыг сайжруулах зорилгоор байгуулагдсан. Энэхүү зохицуулалтад 42 улс нэгдэж үй олноор хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна¹⁴.
- **Азийн бүсийн санаачилгууд** – Зүүн Азийн орнуудын дунд цөмийн зэвсгээс ангид бүс байгуулах тухай хэлэлцээрүүд



¹² <https://www.dfat.gov.au/publications/minisite/theaustraliagroupnet/site/en/index.html>

¹³ https://www.armscontrol.org/specialprojects/nnpm/NSG?utm_source=chatgpt.com

¹⁴ <https://www.wassenaar.org/about-us/>



хийгдэж, зарим улс орон энэ чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

- **Зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх санаачилга (PSI, 2003 он)** – Энэ санаачилга нь хууль бус зэвсгийн наймаа, тээвэрлэлтийг зогсоох чиглэлээр улс орнуудын хооронд мэдээлэл солилцох, хамтран ажиллах, экспортын хяналтыг сайжруулах зорилготой бөгөөд дэлхийн 100 гаруй улс нэгдэн орсон байдаг¹⁵.

- **АНУ, Европын Холбоо, Ази, Номхон далайн бүс нутгийн улсуудын хамтын ажиллагаа** – АНУ, ЕХ болон Азийн орнуудын экспортын хяналт, технологийн хөгжүүлэлт, аюулгүй байдлын хамтын ажиллагааны хэлэлцээрүүд байгуулж, үй олноор хөнөөх зэвсгийн хууль бус худалдаатай тэмцэх чиглэлээр хамтран ажиллаж байна.

Дөрөв. Үй олноор хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэх Монгол Улсын санаачилга, эрх зүйн орчин

Монгол Улс нь үй олноор хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэх олон улсын санаачилга, хамтын ажиллагааг тууштай дэмжиж, идэвхтэй оролцоогоо хангах бодлого баримталж ирсэн. Монгол Улс үй олноор хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэхэд олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, дотоодын хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр дараах үр дүн гаргаж ажилласан байна.

Цөмийн зэвсэггүй бүс Монгол Улс 1992 онд өөрийн нутаг дэвсгэрийг цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлаж, түүнийг эрх зүйн үндэстэй болгон баталгаажуулахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулж ирсэн. Үүний үр дүнгийн нэг нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн ээлжит 53 дугаар чуулган,

1998 оны 12 дугаар сарын 4-ний өдөр "Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус"-ын тухай 53/77/D тоот тогтоол баталсан явдал юм.

Монгол Улсын нутаг дэвсгэрийг цөмийн зэвсгээс ангид байлгах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар бэхжүүлэхэд чиглэсэн төрийн бодлогод бүрэн нийцэж байгаа юм. Монгол Улсын цөмийн зэвсэггүй статус нь олон улсын харилцааны практикт гарч буй шинэлэг хандлага бөгөөд өргөн утгаараа цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх дэглэмийг бэхжүүлэхэд чиглэсэн дэлхийн хамтын нийгэмлэгийн бодлого, хүчин чармайлтад Монгол Улсаас оруулж байгаа тодорхой хувь нэмэр гэж үзэж байна.

4.1. Нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц

Монгол Улс үй олноор хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэх дараах олон улсын гэрээ, конвенцуудад нэгдэж, тэдгээрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байна. Үүнд:

- **Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ (NPT, 1969 он)** Монгол Улс 1972 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр соёрхон баталсан¹⁶.
- **Химийн зэвсгийг хориглох тухай конвенц (CWC, 1993 он)** Монгол Улс 1995 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр нэгдэн орсон¹⁷.
- **Биологийн зэвсгийг хориглох тухай конвенц (BWC, 1972 он)** Монгол Улс 1973 оны 5 дугаар сарын 5-ны өдөр нэгдэн орсон¹⁸.
- **Цөмийн туршилтыг бүрэн хориглох гэрээ (CTBT, 1996 он)** Монгол Улс 1997

¹⁵ <https://www.psi-online.info/psi-info-en/botschaft>

¹⁶ REPORT OF THE GOVERNMENT OF MONGOLIA ON THE IMPLEMENTATION OF THE UNGA RESOLUTION 77/56 (2022) ENTITLED "MONGOLIA'S INTERNATIONAL SECURITY AND NUCLEAR-WEAPON-FREE STATUS" 2024

¹⁷ REPORT OF THE THIRD SPECIAL SESSION OF THE CONFERENCE OF THE STATES PARTIES TO REVIEW THE OPERATION OF THE CHEMICAL WEAPONS CONVENTION

¹⁸ https://en.wikipedia.org/wiki/List_of_parties_to_the_Biological_Weapons_Convention



оны 8 дугаар сарын 08-ны өдөр соёрхон баталсан.¹⁹

- **НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 тогтоол (UN Security Council Resolution 1540, 2004 он)** Энэхүү тогтоолыг гишүүн улс, орнууд дагаж мөрдөх үүрэг хүлээдэг²⁰.

- **Цөмийн зэвсгийг хориглох тухай гэрээ (2017 он)** Монгол Улс 2021 онд соёрхон баталсан²¹.

4.2. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх Монгол Улсын хууль, эрх зүйн орчин

Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, экспортын хяналтын тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр дараах хууль тогтоомжуудыг батласан байна. Үүнд:

- **Терроризмтой тэмцэх тухай хууль (2004 он)** Монгол Улсад терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх эрх зүй, зохион байгуулалтын үндсийг тогтоож, энэ чиглэлээр төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдээс хүлээх үүрэг, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2004 онд батлагдаж байв. Энэ хуулийг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон байна.

- **Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль (2019 он)** үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтоох зорилгоор 2019 онд батлагдаж байсан.

- **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013 он)** мөнгө угаах болон терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эрх зүйн үндсийг тогтоох

- **Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам (2019 он)** Терроризм, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон эдгээр гэмт хэргийг санхүүжүүлэхийн эсрэг тэмцэхтэй холбогдуулж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хүн, хуулийн этгээдийг террорист этгээдийн жагсаалтд оруулах, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, жагсаалтад оруулснаас үүсэх бусад харилцааг зохицуулах, гуравдагч этгээдийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Засгийн газрын тогтоолоор батлагдсан.

- **Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам (2019 он)** Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой үйл ажиллагаа, үүргийг нарийвчлан тодорхойлох зорилгоор Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан.

Нэмэлт мэдээлэл:

- <https://nctc.gov.mn/c/4103986?list=336720&pid=4103986&r=3957478>
- <https://fiu.mongolbank.mn/mn/p/4200>

¹⁹ <https://banmonitor.org/profiles/mongolia>

²⁰ [https://www.un.org/en/sc/1540/about-1540-committee/general-information.shtml#:~:text=United%20Nations%20Security%20Council%20Resolution%201540%20\(2004\)&text=The%20resolution%20obliges%20States%2C%20inter,and%20their%20means%20of%20delivery.](https://www.un.org/en/sc/1540/about-1540-committee/general-information.shtml#:~:text=United%20Nations%20Security%20Council%20Resolution%201540%20(2004)&text=The%20resolution%20obliges%20States%2C%20inter,and%20their%20means%20of%20delivery.)

²¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231273459131>



Тав. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр авч буй арга хэмжээ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн 2004 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 1540 дүгээр тогтоолоор гишүүн орнуудыг үй олноор хөнөөх аюултай цөмийн, химийн болон биологийн зэвсгийг түгээн дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэх, түүнийг гэмт этгээд хууль бусаар үйлдвэрлэх, олж авах, тээвэрлэх, дамжуулах болон ашиглахыг хориглосон арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх, хяналт тавих хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхийг үүрэг болгосон.

Монгол Улсын хувьд 2005 он, 2014 онуудад 1540 тогтоолын үндэсний тайлан, матрицийг боловсруулан хүргүүлж байсан. Улмаар Нэгдсэн үндэсний байгууллагын дэмжлэгтэйгээр 2018 онд үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулсан боловч эцэслэн батлагдаагүй. Терроризмтой тэмцэх зөвлөл нь 2020 онд уг тогтоолын холбогч байгууллагаар томилогдож 2021 онд үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэслэн боловсруулж НҮБ-ын 1540 хороонд хүргүүлсэн байна.

Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд дотоодын эрх зүйн тогтолцоог сайжруулах чиглэлээр дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүний худалдаа, тээвэрлэлтэд хяналт тавих, энэ харилцааг зохицуулсан хуулийн төслийг “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүнд хяналт тавих тухай хууль” нэртэйгээр боловсруулсан бөгөөд цаашид уг хуулийг батлуулах, холбогдох бэлтгэл ажлуудыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

- Европын холбооны хоёрдмол зориулалттай бараа, бүтээгдэхүүний хяналтын жагсаалтыг монгол хэл рүү орчуулах ажлыг НҮБ-ын ЗХА-ны туслалцаатайгаар гүйцэтгэсэн. Цаашид хяналтын жагсаалтыг Засгийн газраар батлуулахаар төлөвлөж байна.

- Дотоодын холбогдох хууль тогтоомжийн хийдэл, сул цэгийг тодорхойлох ажлын хүрээнд НҮБ-ын 1540 хороонд холбогдох хуулиудыг хүргүүлж зарим сайжруулах шаардлагатай зохицуулалтуудыг тодорхойлсон. Үүнтэй холбогдуулан хуулийн төслийг шинэчлэн боловсруулах ажлыг хийхээр төлөвлөж байна.

- Монгол Улс нь Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны нэгдсэн конвенц, Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны Нэмэлт, өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд тус тус нэгдэн орохоор ажиллаж байна.

- Химийн зэвсэг хориглох конвенцыг хэрэгжүүлэх Үндэсний алба Химийн зэвсгийг хориглох тухай хуулийн төслийг боловсруулахаар ажиллаж байна.

- Био аюулгүй байдлыг хангах хүрээнд аюултай өвчин үүсгэгчийн бүртгэл мэдээлэл өгөгдлийн санг бий болгох нөхцөлийг бүрдүүлж байна.



Дүгнэлт

Үй олноор хөнөөх цөмийн, химийн, биологийн зэвсэг нь олон улсын энх тайван, аюулгүй байдалд заналхийлж буй хамгийн том аюул заналын нэг бөгөөд түүнтэй тэмцэх, үл дэлгэрүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа, улс орнуудын дотоодын хууль, эрх зүйн орчин ихээхэн чухал нөлөө үзүүлж иржээ. Олон улсын хамтын нийгэмлэг үй олноор хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэх хяналтын механизм бүрдүүлэх, гишүүн улс орнуудын дотоодын хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хүчин чармайлт гаргасаар байна.

Монгол Улсын зүгээс үй олноор хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэх олон улсын санаачлагыг тууштай дэмжиж, дотоодын эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад өөрийн хувь нэмрээ оруулж ирсэн. Олон улсын геополитикын нөхцөл байдал тогтворгүй байгаа өнөө үед Монгол Улс дотоодын хууль, эрх зүйн орчныг улам сайжруулах, хяналтын механизмыг бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА